

2.12. БИЧВЭР, ТЕКСТИЙН ДИАЛОГ ШИНЖИЙН ТУХАЙ М.БАХТИНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Түлхүүр үг: бичвэр, текст, үг болон өгүүлбэрийн диалог шинж, анхдагч ба хоёрдогч диалог, бичгийн хэлтэй ажиллах тухай.

Товч утга: Оросын төдийгүй өрнийн философи сэтгэлгээнд М.Бахтины үзэл, онол чухал байр суурь эзэлдэг билээ. Бичвэр, текстүүдийн диалог утга холбогдол хийгээд, түүнийг боловсрол, сургалтанд хэрхэн тооцоолох тухай М.Бахтины үзэл баримтлалаас товч толилуулж байна.

Боловсрол сургалтыг өнөөдөр бичвэр, текстгүйгээр төсөөлж болохгүй билээ. Тэгвэл аливаа бичвэр, текст диалог байдаг. Бичвэр, текстийн диалог шинжийг үл хайхрах юм бол бичвэр, текст амьд бүтээлч харилцаанаас холдож, хүмүүнлэг үнэ цэнээ алдана. Бичвэр, текстийн амьдрах талбар нь ойлгохуй. Текст ойлгохуйн орчинд л амьдарч байдаг байна. Бичвэр, текстийн диалог шинжийг нээж илрүүлэх, бичвэр, тексттэй диалог явуулах, диалогийг цааш үргэлжлүүлэх чадвартай болно гэдэг нь бүтээлч сэтгэлгээний чухал шинж бөгөөд эс тэгвээс, сургалт бэлэн мэдлэгийг дамжуулах, тогтоон цээжлэх эцэс төгсгөлгүй үйл явц хэвээр байх болно. Нэг талаас текст бол утга тээгч, соёлын нэг төрөл, нөгөө талаас, тэр санал солилцох үйл ажиллагааны нэг хэлбэр мөн.

Бичвэрийн диалог шинжийг оросын философич, соёл судлаач М.Бахтин (1895-1975) тусгайлан авч үзэж, судалсан байдаг. Эдүгээ М.Бахтины диалогийн тухай үзэл баримтлал Орос оронд төдийгүй, өрнийн философи сэтгэлгээнд чухал байр суурь эзэлдэг. Түүний зохиолуудыг эмхэтгэн 1970-аад оны төсгөлөөр Япон, АНУ-д хэвлэж байсан байна. Хэдийгээр К.Роджерс, М.Бубер тэргүүтэй философичид өрнөдөд М.Бахтинаас өмнө диалогийн тухай үзэл баримтлалаа боловсруулсан ч гэсэн М.Бахтин судлал өрнийн улсуудад (Канад, АНУ, Мексик) хүмүүнлэгийн шинжлэх ухааны хүрээнд судалгааны бие даасан салбар болон хөгжиж байна.

М.Бахтины диалог үзлийн гол онцлог нь тэр анх удаа урлаг, соёлын бүтээлүүдийн диалог төрхийн тухай авч үзсэнд оршино. Түүний диалогийн тухай үзэл үгийн философитой салшгүй холбогддоогоороо онцлогтой. Үг өөрийн мөн чанараараа диалог төрхтэй гэж үздэг. Үгийн энэхүү диалог төрх нь хүний бодол, санаанд, мөн гадагш илрэх хэлбэрийн аль алинд нь илэрч байдаг. Үгийг тодорхой индивид

эзэмшдэг боловч тэр нь хүмүүсийн хоорондын харилцааны үр дүн байдаг. Энэ бол хүний оршин тогтнох буюу бүхий л бүтээлч үйл ажиллагааных нь идэвхтэй хэсэг. Тэрээр ертөнц, хийгээд соёл, символын утганд нэвтрэх үйл явц нь М.Бахтины хувьд үгийн утга судална гэсэн үг юм. М.Бахтины үзлийн төвд бие хүний хөгжил, төлөвшлийн асуудал, индивидуаль чанарын асуудал байдаг бөгөөд энэ нь түүний үг, утга зохиолын тухай үзлийнх үндсэн зорилго болж байдаг юм. Түүний хувьд үг, өгүүлбэр, урлагтай ажиллаж байна гэдэг нь хүнтэй ажиллаж буй хэрэг юм. Амьдарна гэдэг нь диалогт оролцохын нэр. Хүн диалогт нүд харц, гар, сэтгэл, бүх бие, бүхий л үйл ажиллагаагаараа оролцож байдаг. Үг хүний амьдралын диалог талын чухал илэрхийлэл. Бодол, эргэцүүлэл бол эцэс төгсгөлгүй диалогийн урсгал байдаг.

М.Бахтин "К переработке книги о Достоевском", "Проблемы творчества Достоевского", "Философия поступка", "Эстетика словесного творчества", "Проблема речевых жанров" зэрэг зохиолууддаа аливаа бичвэр, текстийг ойлгоно гэдэг бас диалог үүсгэдэг тухай асуудлыг онцлон тайлбарласан байдаг. Бичвэр гэдгийг М.Бахтин маш өргөн утгаар буюу шинжлэх ухааны бүтээл, уран зохиол, философийн бүтээлүүд, бусад төрлийн нийтлэлүүд (захиа, илтгэл г.м.) гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Харин текст гэдгийн дор аливаа бичвэрийн аль нэг хэсэг, бүлэг, сэдвийг мөн түүнчлэн догол мөртөөр хязгаарлагддаг санаануудыг багтаан үзэж байгаа юм. Аль ч бичвэр дэх догол мөртөөр зааглан илэрхийлдэг багц санаанууд, тэр бүү хэл, бичвэр дэх өгүүлбэрүүд ч хоорондоо логик холбоотой, өөр өөрийн утга илэрхийлэгч хэсгүүд байдаг ажээ. Харин бүхэлдээ бичвэр бол нэг үйл явдал, нэгэн утга санаа байдаг. Бичвэр бодит байдлын зураглал, соёл түүхийн өгөгдөхүүн, бас хэрэглэгдэхүүн болж урт удаан хугацаагаар амьдарч байдаг. Жишээлбэл, уран зохиолын баатруудыг хэлж болох юм. Тэд амьд сэрүүнээс ялгаагүй бидний дотор амьдарч эхэлдэг ч явдал бий.

Бичвэр, текстийг ойлгоно гэдэг нь а) хэлний хэрэглэгдэх олон янз байдалд анхаарлаа хандуулахаас эхэлдэг нарийн үйл явц байдаг, б) хэл гэдгийг мөнхүү олон янзаар ойлгодог, тухайлбал, хүний бүтээсэн бүхэн "тодорхой юм хэлж байдаг" гэдэг утгаар хүнийг хүнд төлөөлдөг гэж М.Бахтин үздэг. Түүний хувьд диалог нь "өөрийн энгийн, бас тодорхой шинж чанараараа харилцан ярианы сонгодог хэлбэр мөн"¹. Хүний үйл ажиллагааны бүхий л олон янз байдал нь хэлийг ашиглаж байдаг. Диалогт хэлний ашиглагдах байдал ч хүний үйл ажиллагааны олон янз байдлыг дагаад бас олон янз байдаг. Энэ олон янз байдал нь тодорхой хэллэг, илэрхийлэлд биелэлээ

¹ М.М.Бахтин. Эстетика словесного творчества. Проблема речевых жанров. М.1986. х.264

олж байдаг. Үйл ажиллагааны өвөрмөц нөхцөл байдлуудаас шалтгаалж илэрхийллүүд нь агуулга, хэл зүйн найруулга, зохиомж бүтцээрээ ялгаатай байдаг¹.

М.Бахтин диалогийг бүхэлд нь анхдагч диалог (энгийн, аж байдлын) хоёрдогч диалог (нарийн нийлмэл) гэж ангилж үздэг. Анхдагч диалог гэдэг бол жирийн аж байдал, амьдралын явц дахь харилцан яриа. Харин хоёрдогч диалог гэдэг бол шинжлэх ухааны судалгаа, роман, бүтээл туурвил, нийтлэлийн хэлбэрүүд бөгөөд соёлын харилцааны харьцангуй өндөр, зохион байгуулалттай төвшинд илэрч байдаг. Диалогийн энэхүү сүүлчийн хэлбэрт гол анхаарлаа хандуулсан бөгөөд диалогийн энэ хэлбэрийг тэр нээлттэй диалог гэж нэрлэсэн байх нь ч бас тааралддаг. Хоёрдогч диалогийг ойлгох нь нарийн судалгаа шаардана. Ийм судалгааг хийж байх ёстой хамгийн чухал орон зай нь сургалт бөгөөд энэ орон зайд мэдээллийн эх үүсгүүр болох сурах бичиг, сурвалжууд; судлаачид буюу суралцагчид; бас ийм үйлчилгээг зохион байгуулдаг багш нэгдэж, хамтарч ажиллах юм.

Юуны түрүүнд М.Бахтины үзлээр анхаарах ёстой гол зүйл бол бичвэр текстэнд байгаа хэллэгийн нөхцөл байдлыг сайтар мэдрэх явдал юм. "Хэл бол амьдралд түүнийг бодитой болгож байдаг тодорхой илэрхийллээр дамжиж орж ирдэг, бас тодорхой илэрхийллээр дамжиж амьдрал хэлэнд орж ирдэг"². Энэ нь, нэг талаас хэлний үүсэл, нөгөө талаас хэлийг хэрэглэнэ гэдгийн аль аль нь символчлалын үйл явц байна гэсэн санаа бөгөөд утга энэхүү символыг давж гарах буюу тайлбарлах үйл явц нь жинхэнэ ойлгохуй, өөриймшүүлэлт болох юм. Нөгөө талаас, М.Бахтины бичсэнээр "ямар ч тайлбар өөрөө символ болдог"³. Өөрөөр хэлбэл, тайлбар бас шинэ диалогийн эхлэл болдог байна.

Хэл яриа гэдэг бол тухайн индивидын өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө биежүүлэх хэрэгцээнээс урган гардаг. Аливаа бичвэр, текстийг (диалогийг) ойлгоход янз бүрийн алдаанууд гарч болно. Тухайлбал, харилцааг нь орхиж зөвхөн утгат чанарт анхаарах, аль эсвэл зөвхөн үзэл бодлын утга төгөлдөр байна уу гэдгийг анхаарч, харин хэл ярианд байдаг мэдээлэх чадварыг нь дутуу үнэлэх явдал гарч болно. Хэлний харилцааны нэгж болох тодорхой санал, хэлсэн үг бүхний хил хязгаар нь ярианд оролцогч субъектуудын харилцан солигдолтоор тодорхойлогддог. Жирийн аж байдлын диалогоос эхлээд роман, шинжлэх ухааны бүтээл хүртэлх ямар ч диалог бидний дээр ярьсанчлан эхлэл төгсгөлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, тэдгээрээс өмнө

¹ М.М.Бахтин. Эстетика словесного творчества. Проблема речевых жанров. М.1986.х. 250

² Мөн тэнд х. 252

³ Мөн тэнд.х 362

нь тухайн асуудал, сэдвээр бусад хүмүүсийн санал, үзэл байж байгаа. Дараа нь түүнд хариу болгосон бусдын саналууд гарна. Аль эсвэл үг дуугүй түүнийг ойлгон хүлээн зөвшөөрсөн хэлбэр бас байж болдог. Ийм хариу үйлдлүүд гагцхүү ойлголцол дээр тулгуурлана. Ярьж байгаа хүн бусдадаа ярих боломж олгохын тулд, эсвэл, идэвхтэй ойлгох боломж олгохын тулд өөрийн үгээ зогсоодог. Яриа гэдэг бол хил хязгаартай диалог мөн. Хариулт, сөрөг үзлүүд байнга гарч байдаг.

М.Бахтин анхдагч, хоёрдогч диалогуудын ялгаа заагийн талаар өгүүлсэн байдаг. Хоёрдогч диалог болох уран зохиол, философи, тодорхой шинжлэх ухаан зэрэг соёлын өндөр төвшний бичвэрийн төрлүүдэд диалог өвөрмөц байдлаар илэрдэг. Тухайлбал, ярьж байгаа эсвэл, бичиж буй хүн өөрийн санааны хязгаар дотор өөрөө асуулт тавьж, түүндээ өөрөө хариулах, асуултаа няцаах, өөрөө өөрийгөө няцаах гэх мэт тохиолдол гарч байдаг. Гэхдээ субъектуудын санаа бодлын хил хязгаар нь энгийн ярианыхтай ижил, субъектуудын халагдалт солигдолт байна. Субъект буюу зохиогч нь ертөнцийг үзэх үзэл, хэл найруулгадаа, үзэл бодлынхоо бүхий л эгшинд өөрийн индивидуаль чанарыг шингээж байдаг болохоор энэхүү хил хязгаар нь түгээмэл шинжээ хадгалахын зэрэгцээ бас өвөрмөц, дахин үл давтагдах шинжээ хадгалж байдаг. Бүтээл энэхүү дахин үл давтагдах шинжээрээ тухайн чиглэлийн бусад бүтээлүүдээс ялгарч, өөрийн дотоод хил хязгаарыг барьж тухайн соёлын салбарт буй өөрийн түшиглэсэн бүтээлүүдтэй харьцаж, бас тухайн чиглэлийн зарим бүтээлүүдийг шүүмжлэх, түүнтэй тэмцэх гээд бас диалог үүсгэж байдаг байна. Иймээс бүтээл бол бусдын тавьсан асуултын хариулт, бас асуудлын өрнөл, хариултан ойлгохуй байдгаараа бусдад нөлөөлөх, итгүүлэх, үнэмшүүлэх, шүүмжлэлд өртөх, гэх мэт тухайн соёлын нарийн нийлмэл харилцаанд оролцож байдаг байна.

М.Бахтин хоёрдогч диалогийн төрлүүдийн онцлог шинжүүдийг харьцуулан үзэж тодорхойлсон байна. Философийн болон шинжлэх ухааны бүтээлүүд дэх диалог нь монолог шинжтэй. Учир нь субъектууд нь нэг логикийн дотор, тэрхүү логигоо үндэслэж, тайлбрлаж, няцааж байдаг. Философи болон шинжлэх ухааны диалог нь цэвэр танин мэдэхүйн шинжтэй. Эцэст нь үзэл бодол бүрэн үндэслэгдэж, нэгдэж нийлэх шинж хандлагатай. Тухайлбал, философийн бүтээл байлаа гэхэд, философи өөрөө эргэцүүлэллийн шинжтэй болохоор, судлагдхуундаа хандахдаа өөр бусад философчид тухайн судлагдхуунд хэрхэн хандаж байсан тухай эргэцүүлэхгүйгээр, тэдний үзэлд хариу болгохгүйгээр бичигдэх ямар ч боломжгүй. юм. Тэгэхээр бүтээлийн үүсэх үйл явц өөрөө диалогик шинжтэй байхаас өөр аргагүй юм. Харин

урлаг, утга зохиолын хувьд ямар нэг нэгдэж, нийлэх логикийн тухай яриа байх боломжгүй, ямар нэг дуу хоолой эцэстээ ялах, эсвэл эвсэлдэн нийлэх албагүй, тийм зарчим тавих шаардлагагүй, тэнд янз бүрийн дуу хоолой, тэдгээрийн харилцан хамаарал, холбоо нь өөрөө өрнөл болж байдаг. Дотоод болон гадаад диалогийн харилцан сүлжилдэлт, тасалдал, уулзалт, огтлолцол, сөргөлдөөн цөм өрнөж байдаг. Энэ бүхнээс аль нэг нь зохиогчийн төлөөлөл болж дуу хоолойг нь өргөж байж болно.

Бичвэр, текст бол диалогийн нэг хэлбэр, бусад бүтээл, үзэл бодлуудтай холбоотой, тэдгээрт хариу барьдаг, тэдгээрээс хариу авдаг диалог юм. Бичвэрт байгаа энэхүү диалог шинж хандлага соёлын бусад символ, бүтээлүүдэд ч нийтлэг байна. Тэгэхээр хөг, аялгуу, цэг, зураас, өнгө, гэрэл сүүдэр ч утга илтгэдэг символууд буюу бидэнд нэгийг өгүүлж, мөн тэр хэмжээгээрээ диалог үүсгэж байдаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл, аливаа бичвэр, текст бол тэмдэгтүүдэд хадгалагдсан диалогоос өөр юу ч биш болж таарч байна. Сурна гэдэг нь тэрхүү диалогт оролцоно гэсэн үг. Диалогт оролцоно гэдэг нь аливаа символыг хоёрдмол утгагүй тогтонги зүйл гэж үзэх бус, харин түүний үүссэн нөхцөл, шалтгаан, шийдвэрлэж буй асуудал, дэвшүүлсэн санаа зэргийг илрүүлэн түүнтэй холбогдуулан мэдрэмж, сэтгэгдэл, тайлбараа өгөх замаар үнэ цэнийг нь тогтоох явдлыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тухайн өгөгдсөн диалогийг түүний үүсгүүр болсон өмнөх диалогтой нь холбон үзэж түүнд хариулт өгөх, ингэснээрээ өөрөө бас диалогт оролцоно гэсэн үг.

М.М.Бахтин 1942-1945 онд ерөнхий боловсролын сургуулийн хэл, уран зохиолын багшаар ажиллаж, боловсрол сургалтаар дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх диалог аргаа өвөрмөц байдлаар туршиж байв. Тэрээр диалогийг төрөлх хэл болон уран зохиолын хичээлд ашиглах өргөн бололцоог харуулжээ. Ийм оролдлого, туршилт хийх үндсэн шалтгаан нь сэтгэлгээний загварт баригдаж автсан байдлаас суралцагчдыг чөлөөлөх явдал байлаа. Ингээд тэр өөрийн зааж байсан уран зохиол, төрөлх хэлний хичээлийг хэрхэн ашиглаж болох вэ? гэдэгт гол анхаарлаа хандуулжээ. Өөрөөр хэлбэл, хэл зүй ба өргөн утгандаа онолын хэл шинжлэлд диалогийг хэрхэн ашиглах тухай асуудал байв. Ялагуяа, сурагч бичгийн хэлнийхээ зохиогч болж чадах явдал бол Бахтины хувьд дээрх хичээлүүдээр бүтээлч сэтгэлгээний дадал олж байгаагийн гол шалгуур болох байлаа.

Ийм зорилгынхоо дагуу сурагчийн хэлний индивидуаль төрх буюу яриа болон бичгээр индивидуаль төрхөө илэрхийлэх чадварыг нь чухалчилжээ. Товчоор бол,

ойлгохуйн соёлын тухай авч үзсэн гэж болох юм. Бичгийн хэлний агуулгатай ажиллаж сурах явдлыг онцолж, ойлголтон сэтгэлгээг хөгжүүлэхэд бүхий л сургалтаа чиглүүлж байжээ.

Хүүхдэд бичгийн хэлний бүрэлдэн төлөвших үйл явцыг насны онцлогоор (1-10 дугаар анги хүртэл) үечилж үзжээ. Ингэж үечлэх шалгуур нь дээр дурдсанаар шинжлэх ухааны үндэс судлах, ерөнхий мэдлэг эзэмших явцад сурагчийн юугаар ч сольшгүй, үл давтагдах индивидуаль чанар, буюу "зохиогч" байх чадвар нь хадгалагдаж байна уу хэмээх асуудал байв.

Ингээд дараах дүгнэлтийг хийжээ. Бага ангийн хүүхдүүдэд аман ба бичгийн ярианы хооронд эрс зааг ялгаа байдаггүй, тэд хэлний утгыг хэрэглэхдээ загварт үл баригдан ямар нэг албадлагагүйгээр хэрэглэдэг учраас хэл яриа нь хэдийгээр эв хав, эмх цэгц муутай байж болох авч, амьд догдлолтой, илэрхийлэмж, дүрслэл сайтай, зоримог хурц байдаг. Өгүүлбэр зүй нь ярианы хэлтэй ойролцоо байдаг гэсэн үг. "Хүүхдийн хэлэнд болхи ч гэсэн бичгийн хүний индивидуаль чанар хадгалагдаж байдаг. Хэл нь хэзээ ч эзэн биегүй байдаггүй"¹. гэсэн нь бага ангийнхны хувьд сэтгэлгээ жинхэнэ диалог төрхөөрөө бичгийн хэлэнд ч илэрч байдаг гэсэн үг.

Бага ангийн хүүхдийн хувьд зохиогчийн шинж төрхтэй байсан яриа өсвөр үедээ эзэн биегүй аман яриа болж хувирдаг байна. Үүний учир шалтгааныг Бахтин бичгийн хэлтэй ажилладаг арга зүйн хоцгордож байгаагийн үр дүн гэж үзсэн байна. Ийм хувирал, өөрчлөлт 7 дугаар ангиас эхлээд 8, 9 дугаар ангид оргилдоо хүрнэ. Хэлний диалог төрх алдагдаж, хүүхдүүд цэвэр номын утга, зохиолын хэлээр бичиж эхэлдэг. "Тэдний хувьд сурах бичгүүдэд дархлаажсан, стандартат хэл үлгэр загварын үүрэг гүйцэтгэж эхэлснээр сурагчид янз бүрийн оригиналь дүрслэл, хурц бичлэг, номныхоос ялгаатай дүрслэлээс айж эхэлдэг. Тэд зөвхөн нүд харцанд зориулж бичдэгээс гадна, бичсэн зүйлээ ямар ч аялгуу, өргөлт, мөн үйлийн эзний дүр, хоолойгоор уншдаггүй. Тэдний хэл үнэндээ бол (дүрмийн алдаа байхгүй ч) эзэн биегүй, өнгө, золбоогүй болж эхэлдэг. Хэлний стандартад баригдсан өнгө төрх нь сурагчдад юугаараа ч юм байх ёстой эерэг зүйл мэт санагддаг"². Ийм байдалд оруулж буй сургалтын аргад юуг сөргүүлэн тавьж, ямар арга замаар гарч болох вэ?, амьд хэлтэй дахин тэднийг яаж ойртуулах вэ? гэдэг нь Бахтины хувьд гол асуудал байсан юм.

¹ М.М.Бахтин. Вопросы стилистики на уроках русского языка в средней школе. //Русская словесность. 1994. №4. х.55

² Мөн тэнд. х.55

Сэтгэлгээг загвараас гаргах өөрчлөлтийг 7 дугаар ангиас эхлэн өгүүлбэр зүйн үндэс судлах хичээлээр хэрэгжүүлж эхэлжээ. Өгүүлбэр зүйн анализыг найруулгын анализтай хамт хийж туршсан байна.

Бичгийн хэлний номчирхсон байдлаас гаргах энэхүү үйл ажиллагаа 8 дугаар ангид идэвхтэй үргэлжлэх бөгөөд 9 дугаар ангиас эхэлж сурагчид мухардлаас гарч, соёлтой, амьд бүтээлч хэлний замд орж ирнэ гэж тооцоолсон. “Эзэн биегүй номын хэл, тэр тусмаа дэндүү номчирхсон догшин хэл нь хагас боловсролтойн шинж. Соёлыг бүрэн төгс эзэмшсэн хүн тийм хэлээр ярьдаггүй¹. Хэл зүй нь утга санааны найруулгаас хөндий байх, найруулгын тайлбаргүй байгаа сургалт нь хүүхдүүдэд өөрсдийн хэлийг хөгжүүлэх боломж олгодоггүй гэж үзээд өөрийн гэсэн арга барилаар ажиллаж эхэлжээ.

Бахтин хавсарсан нийлмэл өгүүлбэр (ХНӨ) сонгож аваад түүнийг дуу хоолойны өнгө, гар биеийн хөдөлгөөн зэрэг илэрхийлэх өнгө аясыг ашиглан диалог болгон хувиргаж, ингэснээрээ судлаачдад дотоод диалог үүсгэх, мөн ингэж хувиргахтай холбогдуулан зохиолын баатруудын хооронд диалог үүсгэх, мөн зохиогч ба уншигчийн хооронд диалог үүсгэх аргаар сурагчидтайгаа ажиллаж байсан байна. Хүүхдийн бичгийн хэлэнд анхаарал тавих, хөгжүүлэх, бататгах явдалд зохиогч-баатар-уншигч гэсэн гурвалсан диалогийг ашигласан байна. Тэр ХНӨ-ийг диалог үүсэхэд хамгийн тохиромжтой гэж үзэж, ихэвчлэн Достоевский, Пушкин, Гоголь зэрэг зохиолчдын бүтээлээс гол төлөв холбоосгүй ХНӨ сонгож авч ажилладаг байжээ. Ингээд тодорхой жишээ болгох зорилгоор түүний диалогийн загвараас үзүүлье.

Уран уншигчаас диалог эхэлнэ. Текстийг уншиж буй дүр төрх энд их чухал. Тухайлбал, дуу хоолойны өнгө аяс, гар, биеийн хөдөлгөөн, нүүр царайны байдал, тэр бүү хэл нүдний харцанд ч диалог төрх илэрдэг гэсэн үг. “*Найз нөхөдгүй – би уйтгартай байна.*” (А.С.Пушкин) гэсэн ХНӨийг уран уншигч уншсаны дараа хэл зүйчийн зүгээс тухайн өгүүлбэрт ямар нэг жүжиглэсэн өнгө аяс байхгүй, энэ бол жирийн хавсарсан нийлмэл өгүүлбэр байсан гэх мэтээр саналаа хэлнэ.

Дараагийн оролцогч дүрэм зүйч бөгөөд тэр ХНӨийг холбоостой болгосноор өгүүлбэр “*Найз нөхөдгүй болохоор би уйтгартай байна.*” хэлбэрт орно.

Гэтэл найруулга зүйч өгүүлбэрийг ингэж өөрчлөх нь Пушкины хэрэглэсэн •нөхцөл байдалтай ерөөс нийцэхгүй байгаа талаар өөрийн бодлоо хэлнэ. Дүрэм зүйч

¹ М.М.Бахтин. Вопросы стилистики на уроках русского языка в средней школе. //Русская словесность. 1994. №4. х.55

хоёр шинэ хувилбар гаргаж ирнэ. *“Найз нөхөдгүй тул уйтгартай байна.”*; *“Уйтгартай байна, яагаад гэвэл найз нөхөд алга.”*

Энэ хоёр өгүүлбэрийг хэлэлцсэнээр хэлний дүрэм талаасаа хоёул зөв гэсэн саналд очсоноор хэл зүйч, найруулагч хоёр зөвшилцөж болно. Гэтэл яруу найрагч ингэж хувиргах нь Пушкины өгүүлбэр дэх хурц, тод өнгө аясыг үгүй хийж, хүйтэн хөндий, үхмэл болгож, амьд төрхийг нь алдагдуулж байгаа тухай бас ярина.

Мэдээж хэрэг, энэ диалогт дэвшигдэж буй саналуудыг шүүмжлэх, дэмжихтэй холбогдсон санал бодол ангид чөлөөтэй гарсаар байгаа.

Уран уншигч өгүүлбэрийг холбоос үгтэй нь уншиж үзүүлэхэд холбоос үгнүүд болох *“болохоор”*, *“тул”*, *“яагаад гэвэл”* хэмээх үгнүүд өгүүлбэрийг нуршуу болгож байгаа тухай санаа бас гарч ирнэ.

Холбоос үгнүүд буюу *“болохоор”*, *“тул”*, *“яагаад гэвэл”* гэсэн үгнүүдийн нуршуу болгож байгаа тухай санааг найруулагч хэлнэ. Ингээд сурагчид холбоос үгнүүдэд онолын дүн шинжилгээ хийх юм. Үүнд, өгүүлбэрийн шинж төрх хэрхэн өөрчлөгддөг, бас шинжлэх ухааны болон энгийн яриа, утга зохиолын хэлэнд ийм зүйлийг ойлгохгүйгээр хэрэглэнэ гэдэг боломжгүй талаар ярилцана. Бас ХНӨ-ийг холбоосгүйгээр хэрэглэгдэх нөхцөлүүдийг тодотгон тайлбарлана. Мөн түүхч холбоос үг хэрхэн үүсч, хэрэглэгдэж ирсэн талаар ярина. Уран зохиолд холбоосгүй ХНӨ ихээхэн хэрэглэгддэгийн учрыг ярина. Мөн түүнчлэн утга зохиолын хэл, шинжлэх ухааны хэл, ярианы хэл зэргийн онцлогийг ч ярьж болно. Утга зохиолын хэлийг ярианы хэлтэй ойртуулахад гарах саад бэрхшээл, эртний үг хэл нь орчин үеийн амьд хэлтэй хэрхэн зөрчилддөг тухай яриа бас үүсч болно.

Ийм байдал үргэлжилсээр үгийн нууц ба түүхийн нууцыг уудлан гаргаж ирэх жишээтэй. Тухайлбал, зураачийн хувьд үг *“амьд байгалийн нэг хэсэг”*, үгэнд гаднаас өнгө төрх өгөх боломжгүй, өөрөөр хэлбэл, үгээр дамжуулан мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх бололцоогүй байхад, үргэлжилсэн үгийн зохиолчийн хувьд үг орон зай цаг хугацааны шинжтэй болж, эмх цэгц нь илүү чухалд тооцогдох гэх мэт олон зүйлийг мэдэж авах бололцоотой болох ажээ. Бас унших арга барил нь (дуу хоолойны өнгө, гар, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал) ганц үгийг ч үйл явдал болгон амилуулж болдог, бичих дүрэмд сурах, яруу найргийн хэлийг үхүүлэхгүй байх гэх мэтийн дадал чадваруудыг эзэмших юм.

Резюме

Особое место в ряду русских философов, оказавших существенное воздействие на развитие западной философской мысли, занимает М.М.Бахтин. Парадигмой всего творчества М.М.Бахтина является идея диалога. В статье рассматривается концепция М.М.Бахтина о диалоге в письменной речи и о возможностях их использования при формировании творческого мышления школьников.

НОМ ЗҮЙ

1. Бахтин М.М. Эстетика словесного творчества. Проблема речевых жанров. М.1986
2. Бахтин М.М. Вопросы стилистики на уроках русского языка в средней школе. //Русская словесность. 1994. №4.
3. История философии. Ростов-на-Дону. 2004